



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>


2019. 07. 03 № 02/2008

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2019 оны эхний хагас жилийн тайлан мэдээг хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

ДЭД САЙД  Д.ЗАГДЖАВ

08 2139

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны
2019 оны...⁰⁷...сарын...⁰³...өдрийн
~~03/2008~~...албан бичгийн хавсралт

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ БОЛОН АЛБАН ТУШААЛТАНД
2019 ОНД ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН
/2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР/

ХҮСНЭГТ №1

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт %
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Хугацаа болоогүй	
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	159	146	-	-	13	100%
2	Ашигт малтмал, газрын тосны газар	304	283	-	7	14	93%
НИЙТ		463	429	-	7	26	98.4%

2019 ОНД ИРГЭДЭЭС УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ /хэлбэрээр/

ХҮСНЭГТ №2

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Үүнээс:				
			Бичгээр	Цахимаар	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	159	159	-	-	-	-
2	Ашигт малтмал, газрын тосны газар	304	304	-	-	-	-
НИЙТ		463	463	-	-	-	-

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА

ХҮСНЭГТ №3

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал тоо /нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь
1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Нийт 463 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс хүний нөөц, дэмжлэг туслалцаа хүссэн 229 буюу 49.4%, тусгай зөвшөөрлийн чиглэлээр 84 буюу 18.1%, геологи, уул уурхайтай холбоотой асуудлаар 26 буюу 0.5%, түлш, газрын тосны чиглэлээр 6 буюу 0.1% бусад чиглэлээр 118 буюу 25.4%-тай байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ИРГЭДЭЭС
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол болон бусад хууль тогтоомжийн дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газарт байгууллага, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг бүртгэн авч, судалж шийдвэрлэн хуулийн хугацаанд хариу өгч ажиллав.

Тус яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга, чиг хандлага, шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, тайлан мэдээг яамны удирдлагын шуурхай хуралдаанд танилцуулж гарсан дүгнэлт, шийдвэрийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажиллаж байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 463 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 463 байна. Эдгээрээс шийдвэрлэж хариуг албан бичгээр өгсөн 434, утсаар 5, бусад хэлбэрээр 24 буюу хугацаа болоогүй 26, хугацаа хэтэрсэн 7 өргөдөл ба шийдвэрлэлт 98.4%-тай байна.

Нийт 463 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс хүний нөөц, дэмжлэг туслалцаа хүссэн 229 буюу 49.4%, тусгай зөвшөөрлийн чиглэлээр 84 буюу 18.1%, геологи, уул уурхайтай холбоотой асуудлаар 26 буюу 0.5%, түлш, газрын тосны чиглэлээр 6 буюу 0.1% бусад чиглэлээр 118 буюу 25.4%-тай байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хандаж ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд явагдсан гэж дүгнэж байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
УДИРДЛАГЫН ШУУРХАЙ ХУРАЛДААНЫ
ПРОТОКОЛ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны удирдлагын шуурхай хуралдаан 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хуралдав. Хуралдаанаар тус яаманд 2019 оны эхний хагас жилийн байдлаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга М.Баяраа танилцуулав.

Өгөгдсөн үүрэг даалгавар:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдаас иргэдээс ирүүлсэн санал, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж хариуг холбогдох иргэн болон байгууллагад цаг алдалгүй хүргүүлж ажиллахыг үүрэг болгов.